МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр　　　Дугаар А/160　　　Номгон

Монголын хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.8, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын 2.1, Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны А/45 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2.Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 19,940.000 (Арван есөн сая есөн зуун дөчин мянга) төгрөгийг Аймгийн засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Монголын хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулж, холбогдох тайлан мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Б.Отгонбямба)-т үүрэг болгосугай.

625010479

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын
24-ны өдрийн А/160 дугаар захирамжийн
01 дүгээр хавсралт

# ХҮҮХДИЙН СПОРТЫН VIII НААДМЫН АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Ажлын хэсгийн дарга:**

Б.Наранбаяр - Аймгийн Засаг даргын орлогч

**Гишүүд:**

| | |
|---|---|
| С.Байгалмаа | Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга |
| В.Наранчимэг | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Б.Мөнхбаяр | Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа |
| Н.Энхжаргал | Эрүүл мэндийн газрын дарга |
| Б.Пүрэвдавга | Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга |
| Ж.Алтанцэцэг | Боловсролын газрын дарга |
| Н.Мэндбаяр | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга |
| Б.Лхаасүрэн | Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Б.Энхзаяа | Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан |

Нарийн бичгийн дарга:

Б.Отгонбямба Биеийн тамир, спортын газрын дарга

________o0o________

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/40 дугаар захирамжийн 02 дугаар хавсралт

## МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН VIII НААДМЫН АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

| № | Нэр төрөл | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тэргүүн байр | 2 | 1000000 | 2.000,000 |
| 2 | Дэд байр | 2 | 700000 | 1.400,000 |
| 3 | Гутгаар байр | 2 | 500000 | 1.000,000 |
| 4 | Медаль | 627 | 20000 | 12.540,000 |
| 5 | Шүүгчийн цалин | 30 | 100,000 | 3.000,000 |
| 6 | **Нийт дүн** | | | **19.940,000** |

oOo

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24.. ны өдрийн 1/140 дугаар захирамжийн
.03 дугаар хавсралт

Монголын хүүхдийн спортын VIII наадмын
анхан шатны тэмцээнийг зохион байгуулах
тухай

**Нэг. Зорилго.**

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээний зорилго нь спортын 14 төрлийг сурталчлах, өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, спорт сонирхогч хүүхдийн тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд Баянхонгор аймгийн өсвөр үеийн шигшээ баг, тамирчдыг оролцуулахад оршино.

**Хоёр. Удирдлага зохион байгуулалт**

2.1 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээний ерөнхий зохион байгуулалтыг Биеийн тамир, спортын газрын ажлын хэсэг нэгдсэн зааврыг удирдлага болгон хэрэгжүүлнэ.

2.2 Биеийн тамир, спортын газар нь Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээний ерөнхий зохион байгуулалтыг хариуцах ба Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлагийн газар, Ерөнхий боловсролын сургуулиуд , спортын холбооны төлөөллөөс бүрдэнэ.

2.3 Ерөнхий боловсролын сургуулийн захиргаа, биеийн тамирын багш нар баг тамирчдаа бэлтгэн оролцуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

2.4 Анхан шатны тэмцээнд оролцох тамирчид өөрийн нутаг дэвсгэрт байрлах өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, харьяаллын дагуу давхардал үүсгэхгүйгээр спортын нэг төрлийг сонгон оролцоно.

2.5 Есөн жилтэй сургуулийн 1-9 дүгээр ангид суралцаж төгссөн сурагч, 10,11,12 дугаар ангидаа өөр газарт шилжин суралцаж байгаа суралцагч нь үндсэн 1-9 дүгээр ангид суралцаж төгссөн сургуулийн нэр дээр оролцож болно.

2.6 Анхан шатны тэмцээнүүдийг олон улсын дүрэм, журамд нийцүүлэн Биеийн тамир, спортын газраас томилогдсон шүүгч нар зохион байгуулна.

## Гурав. Зохион байгуулагдах хугацаа, спортын төрөл

3.1 Хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулна.

3.2 Спортын үндсэн төрөл:

1. Бадминтон
2. Воллейбол
3. Дугуй
4. Сагсан бөмбөг 5x5
5. Сагсан бөмбөг 3x3
6. Усан сэлэлт
7. Байт харваа
8. Ширээний теннис
9. Шатар
10. Даам
11. Чөлөөт бөх
12. Жүдо
13. Хөнгөн атлетик
14. Футзал

Дөрөв. Спортын төрөл, зохион байгуулах хугацаа, зай жин насны ангилал:

| № | Спортын төрөл | Ангилал, зай, жин, хүйс | Насны ангилал | Зохион байгуулах хугацаа | Хариуцах албан хаагчийн нэр, утасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **ҮНДСЭН ТӨРӨЛ** | | | | | |
| 1 | Байт харваа | Ганцаарчилсан 60м<br>Холимог хос 60м | 15-17 нас, | VI/03-04 | Б.Мөнхэрдэнэ<br>89303797 |
| 2 | Бадминтон | Ганцаарчилсан<br>Дан хос<br>Холимог хос | 14-17 нас, Нэг тамирчин 2 төрөлд оролцож болно. | III/31-IV/01 | М.Мөнхтулга<br>80115596 |
| 3 | Волейбол | Эрэгтэй 12<br>Эмэгтэй 12 | 15-17 нас<br>2008.01.01<br>2010.12.31 | III/25-27 | С.Идэрбаясгалан<br>94004006 |
| 4 | Даам | 100 буудалт даам<br>Эрэгтэй 1<br>Эмэгтэй 1 | 13 нас<br>14-17 нас | IV/01-02 | Ц.Даваасүрэн<br>80084895 |
| 5 | Дугуй | Уулын бартаат замын уралдаан<br>Эр 1<br>Эм 1 | 13-14 нас<br>2011.01.01<br>2012.12.31 | VI/03-04 | Г.Олонбаяр<br>86224024 |
| | | Уулын марафон уралдаан<br>Эр 1<br>Эм 1 | 15-16 нас<br>2009.01.01<br>2010.12.31 | | |
| 6 | Жүдо | Эр-50кг, 55кг, 60кг, 66кг, 73кг, 81кг, -90кг,+90кг эрэгтэй | 15-17 нас<br>2008.01.01<br>2010.12.31 | III/31 | Л.Батэрдэнэ<br>88159474 |
| | | Эм-40кг, 44кг, 48кг, 52кг, 57кг, 63кг, -70кг, +70кг эмэгтэй | 15-17 нас<br>2008.01.01<br>2010.12.31 | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 7 | Усан сэлэлт | Өвөөр даллах 50м, 100м Эр, Эм | 7-8 нас 2017.01.01 2018.12.31 | VI/03-04 | Д.Баасанжаргал 80395959 |
| | | Араар даллах 50м, 100м Эр, Эм | 9-10 нас 2015.01.01 2016.12.31 | | |
| | | Мэлхий сэлэлт 50м, 100м Эр, Эм | 11-12 нас 2014.01.01 2013.12.31 | | |
| | | Эрвээхэй сэлэлт 50м, 100м Эр, Эм | 13-14 нас 2012.01.01 2011.12.31 | | |
| 8 | Сагсан бөмбөг 5х5 | Эрэгтэй 12 Эмэгтэй 12 | 15-17 нас 2008.01.01 2010.12.31 | IV/01-02 | Х.Доржсамбуу 88992198 |
| 9 | Сагсан бөмбөг 3х3 | Эрэгтэй 4 Эмэгтэй 4 | 15-17 нас 2008.01.01 2010.12.31 | VI/03-04 | Х.Доржсамбуу 88992198 |
| 10 | Шатар | Эрэгтэй 1 Эмэгтэй 1 | 12 нас 13-17 нас | VI/03-04 | Б.Мөнхбат 89952855 |
| 11 | Хөлбөмбөг | Эрэгтэй 20 Эмэгтэй 20 | 14-15 нас 2010.01.01 2011.12.31 | IV/01-02 | Л.Амарбаясгалан 95231635 |
| 12 | Хөнгөн атлетик | 100м, 400м, 800м, 1500м, 5000м | 15-17 нас 2008.01.01 2010.12.31 | VI/03-04 | М.Энхзаяа 94004026 |
| | | Уртын харайлт | | | |
| | | 4х100м, 4х400м | | | |
| 13 | Чөлөөт бөх | 45кг, 48кг, 51кг, 55кг, 60кг, 65кг, 71кг, 80кг, 92кг, 110кг эрэгтэй | 15-17 нас 2008.01.01 2010.12.31 | VI/04-05 | Ж.Баасанбат 88006255 |
| | | 40кг, 43кг, 46кг, 49кг, 53кг, 57кг, 61кг, 65кг, 69кг, 73кг эмэгтэй | 15-17 нас 2008.01.01 2010.12.31 | | |
| 14 | Ширээний теннис | Ганцаарчилсан | 8 - доош 9-10 нас 11-12 нас 13-14 нас 15-17 нас | III/31-IV/01 | Б.Эрдэнэсод 89585454 |
| | | Багийн төрөл | | | |
| | | Холимог хос | | | |

Тав. Тэмцээний техникийн зөвлөгөөнд оролцох журам:

5.1 Сургуулийн шигшээ баг тамирчдын мэдээллийг спортын төрөл тус бүрээр боловсруулж Биеийн тамир, спортын газарт ирүүлсэн байна. /Мэдүүлгийн маягтыг хавсралтаар хүргүүлэв/

5.2 Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 28-наас 30-ны 12.00 цаг хүртэл Биеийн тамир, спортын газрын 102 тоотод хүлээн авна.

5.3 Мэдүүлгийг тухайн сургуулийн захирал  гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.  Эмчийн үзлэгээр хамрагдсан мэдээллийг хавсаргана.

5.4 Хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээнүүдийн нэгдсэн техникийн зөвлөгөөн 2022 оны 03 дугаар сарын 31 өдрийн 14.00 цагт Биеийн тамир, спортын газрын хурлын танхимд явагдана.

5.5 Хүүхдийн спортын зуны  VIII наадмын анхан шатны тэмцээнд оролцох байгууллага бүр оролцох эрхийн төлбөр болох 300.000 төгрөгийг Биеийн тамир, спортын газрын нэмэлт данс болох төрийн сангийн  100030034410 дансанд тушаасан байна.

5.6 Мандатыг багуудад нэгдсэн журмаар олгох бөгөөд мандат авахад доорхи бичиг баримтуудыг бүрдүүлэн оролцоно. Үүнд: Төрсний гэрчилгээ, Сурагчийн хувийн хэрэг, Иргэний үнэмлэх, Гадаад паспорт,  Цээж зураг \4х3\ 1%, \тамирчин нэг бүр дээр\

5.7 Мандат олгосны дараа тухайн төрлийн техникийн зөвлөгөөнийг хийх бөгөөд багийн ахлагч, дасгалжуулагч сугалааг хийнэ.

5.8 Мэдүүлэг ирүүлээгүй сургуулийг Хүүхдийн спортын зуны  VIII наадмын анхан шатны тэмцээнд оролцуулахгүй.

5.9 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээний дүнг  спортын төрлүүдийг нэгтгэн,  нийлбэр дүн гаргана.

'Зурга. Оролцогчдод тавигдах шаардлага, оролцох журам

6.1 Тамирчин нь харьяаллын бус сургууль, сумаас наадамд оролцсон тохиолдолд тэмцээнээс хасах, амжилтыг хүчингүйд тооцно.

6.2  Нэг тамирчин өөрийн сонгосон спортын нэг төрөлд  оролцоно.

6.3 Тухайн байгууллага нь өөрсдийн тамирчдын тэмцээнд оролцох бүхий л бэлтгэлийг хангаж ажиллана.

6.4 Сум, сургууль нь байгууллагын логотой тугийг барьж нээлтийн үйл ажиллагаанд жагсана.

6.5 Сум, сургууль, байгууллагууд нь Засгийн газрын хэргэжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын хамтарсан 2024 оны А/237, А/76, А/604 дүгээр тушаал “Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам ”-ыг мөрдлөг болгон ажиллана.

Долоо. Шагнал урамшуулал:

шагнаж урамшуулна.

7.2 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээний спортын төрлүүдэд амжилттай оролцсон Баянхонгор сумын /Баянхонгор аймгийн төвийн сургууль/ ерөнхий боловсролын сургуулиудын амжилтыг нэгтгэн байгууллагын дүн гаргаж 1, 2, 3, дугаар байр эзлүүлнэ.

7.3 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын анхан шатны тэмцээний спортын төрлүүдэд амжилттай оролцсон Сумдуудын сургуулиудын амжилтыг нэгтгэн байгууллагын дүн гаргаж 1, 2, 3, дугаар байр эзлүүлнэ.

7.4 Тэргүүн байр Цом, Өргөмжлөл, 1.000.000 төгрөг

7.5 Дэд байр Цом, Өргөмжлөл, 700.000 төгрөг

7.6 Гутгаар байр Цом, Өргөмжлөл, 500.000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна.

__________oOo__________